

БАТЛАВ:  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА *Х.ЭНХЦЭЦЭГ*



## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Авто зам, замын байгууламжийн нэр: Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м (Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум)

Нэг. Ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд:

1. Ажлыг гүйцэтгэхдээ техник, технологийн хяналтын инженерээр технологийн аргачлал батлуулан техникийн шаардлага бүрэн хангагдсан гэж үзвэл холбогдох газруудаас зөвшөөрлийг авч ил, далд ажлын актыг баталгаажуулж, үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг шалгуулж, дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэнэ.

2. Авто зам, замын байгууламжийн ажлыг гүйцэтгэхдээ бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээ болон оршин суугчдын ая тухтай, аюулгүй зорчиход ямар нэгэн саад бэрхшээл учруулахгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийнэ.

3. Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг тогтмол өгч ажиллана.

Хоёр. Захиалагчийн хяналт:

1. Техник технологийн хяналтын баг нь Захиалагчийг төлөөлж авто зам, замын байгууламжийн ажлыг гүйцэтгэж эхлэхээс дуусах хүртэлх бүх технологийн үйл ажиллагааг хянан хариуцаж ажиллана.

2. Батлагдсан ажлын зураг төсөл, норм, дүрэм, технологийн шаардлагыг зөрчсөн нөхцөлд захиалагч байгууллагын эрх бүхий төлөөлөгчид, техник технологийн хяналтын баг, мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчид барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авна.

Гурав. Гүйцэтгэгч байгууллага:

1. Гүйцэтгэгч байгууллага нь авто зам, замын байгууламжийн ажлыг тендерийн баримт бичиг, батлагдсан ажлын зураг төсөл, төсөв, тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.

2. Ажлын талбайд журнал байнга хөтөлж, захиалагч, хяналтын зөвлөх багийн өгсөн үүрэг даалгавар, шаардлага, дүгнэлтийн биелэлтийг гаргана.

3. Ажил гүйцэтгэх явцад үе шатны ажил тус бүрийг фото зургаар баталгаажуулан далд ажлын акт үйлдэнэ.

4. Ажлын явцад өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрсэн байгууламжуудыг нөхөн сэргээн засварлаж хэвийн байдалд оруулна.

4. Ажлын явцад өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрсэн байгууламжуудыг нөхөн сэргээн засварлаж хэвийн байдалд оруулна.

5. Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшгаас сэргийлэн даатгалд бүрэн хамрагдан аюулгүй байдлыг хангаж ажиллана.

6. Авто зам, замын байгууламжийн ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагч, технологийн хяналтын инженерийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд хийж гүйцэтгэсэн ажилдаа баталгаа гаргана.

7. Зам, замын байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэлийн зургаар баталгаажуулна.

8. Хэрвээ зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 14 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.

Дөрөв. Ерөнхий төлөвлөлт, техникийн үзүүлэлт, шийдэл, цар хүрээ, тавигдах шаардлага:

Гүйцэтгэгч дараах зүйлээс бүрдсэн ажлын төлөвлөгөөг захиалагчаар батлуулахаар танилцуулна.

1. Гүйцэтгэх ажлын нарийвчилсан график

2. Санхүүжилтийн хуваарь:

3. Гүйцэтгэгч гэрээний баримт бичгүүдийг холбогдох байгууллагуудад танилцуулж авто замын барилга, байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг тухай бүр авсан байна.

Байршил, одоо байгаа байдал:

Трасс 1: Баруун-Урт сум Петровис ШТС-ын баруун салбарын баруун талаар хойшоо тойрч Баруун-Урт голоор дамжин зүүн тийш эргэн урагшаа Тал булаг, Түмэнцогт чиглэлд гарах гарц хүртэл, Трасс 2: Наадмын талбайгаас зүүн тийш Сүхбаатар сум чиглэлд гарах ердийн бартаа, дэржигнүүр, тоосжилт ихтэй орон нутгийн чанартай шороон зам, Баруун-Урт голын эхээр дамжих авто зам.

Төлөвлөлт, техникийн үндсэн үзүүлэлт:

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө,

Дагуу болон хөндлөн огтлолын төлөвлөлтийг Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04, БНБД 32-01-04, ЗЗБНБД22-004-2016-ийн дагуу төлөвлөсөн.

Трасс 1: Баруун-Урт сум 4.6 км авто зам

Замын далангийн өргөн 11 м, зорчих хэсгийн өргөн 7 м, хөвөө 2x0.5м, хөлдөлтөөс хамгаалах үе 30 см, цементээр бэхжүүлсэн суурь 20 см, суурь асфальбетон хучилт 5 см, өнгө асфальтбетон хучилт 4 см байна. Ажлын зураг, тоо хэмжээний дагуу гадаргуугийн ус зайлуулах байгууламж, ус зайлуулах хоолой, босоо, хэвтээ тэмдэг тэмдэглэгээ, туузан хашлага хийгдэнэ. Батлагдсан зураг төслийн дагуу Баруун-Уртын голын дээгүүр 24 у/м төмөрбетон гүүр тавигдана.

Трасс 2: Баруун-Урт сумаас Сүхбаатар сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг зураг төсөл

(шифр:11/20 Боть-II)-өөс Наадмын талбайн зүүн урд хатуу хатуу хучилттай авто замын төгсгөлөөс Сүхбаатар сум чиглэлд гарах 4.7 км авто зам.

Замын далангийн өргөн 11 м, зорчих хэсгийн өргөн 7 м, зөөврөөр далан байгуулах, хөлдөлтөөс хамгаалах үе 30 см хийгдэнэ. Ажлын зураг, тоо хэмжээний дагуу гадаргуугийн ус зайлуулах байгууламж, ус зайлуулах хоолой хийгдэнэ.

Ажлын зураг, тоо хэмжээгээр инженерийн шугам сүлжээг хүчитгэх, 0,4-10кВ-ын ЦДАШ шилжүүлэх ажлын зардлыг төсөвт тооцсон болно.

Төлөвлөж буй авто замын зураг төсөл нь замын байгууламжийн ажлын зураг, төсөв, тайлбар бичиг, техникийн шаардлага, инженер геологийн судалгааны дүгнэлт, байр зүйн зургийн тайлангаас бүрдэнэ.

Тус зам нь одоо Монгол улсад мөрдөгдөж байгаа ЗЗБНБД22-004-2016 “Авто зам төсөллөх”-ийн хүснэгт 1.1, 1.2 дагуу 2А зэрэг буюу 2 зурвастай БНБД 30-01-04 “ХОТ, ТОСГОНЫ ТӨЛӨВЛӨЛТ БАРИЛГАЖИЛТЫН НОРМ, БА ДҮРЭМ”-ийн хүснэгт 10-н дагуу нутаг дэвсгэрийн туслах гудамж, замд хамрагдаж байна. Авто зам уур амьсгалын хээрийн II В бүсэд хамаарагдана. Эдгээр үзүүлэлтүүдийг баримтлан авто замыг төлөвлөсөн.

Авто замын барилга байгууламжийн ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/, стандартыг баримтлан төсөвт тусгагдсан ажлуудыг орхигдуулахгүйгээр технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Үүнд:

- Авто замын уур амьсгалын геотехникийн нөхцөл АЗУАГН 2.01.01-2004
- Авто замын хучилтын материалын туршилт-шинжилгээ, үзлэг хийх байгууллагуудад тавигдах шаардлага MNS ASTM D3666:2005
- Авто зам төсөллөх ЗЗБНБД22-004-2016
- Хот суурины гудамж замын төлөвлөлт БНБД32-01-07
- Авто замын гүүр хоолой төсөллөх БНБД32.02.03
- Гүүрэн байгууламж төсөллөх БНБД 3.06.04-88, БНБД 3.03.01-88, БНБД 3.03.02-90
- Геодизийн ажил БНБД3.01.03-88, 11-08-06
- Газар хөдлөлтийн бүс нутаг барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНБД 22-01-01/2006, БНБД 32.02.11
- Авто замын уян хучилтыг төсөллөх тооцооны аргачлал
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн норм БД31-101-04
- Авто замын тэмдэг, тэмдэглэл 4597:2013
- Бусад

Ажлын зураг, төсөвт тусгагдаагүй боловч зайлшгүй шаардлагаар нэмэлтээр хийгдэх болон шугам сүлжээний ажилтай холбоотойгоор зам талбай сэтлэх, инженерийн шугам сүлжээг шилжүүлэх зэрэг бусад нэмэлт ажлуудыг магадлашгүй ажлын зардлаар хийнэ.

Магадлашгүй ажлыг хэрхэн, ямар ажилд зарцуулах талаар Захиалагчийг төлөөлж техник хяналт хэрэгжүүлж байгаа байгууллага болон хяналтын инженер танилцуулж, шийдвэрийг Захиалагч буюу аймгийн ЗДТГ, Хөгжлийн бодлого

төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс гаргана. Зөвшөлцөөгүй, танилцуулаагүй, хянагдаагүй тохиолдолд магадлашгүй ажлын зардлыг санхүүжүүлэхгүй болно.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь: импортын материал худалдан авах тохиолдолд тохиролын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторын шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал "Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ", лабораторийн шинжилгээний дүн, падаан хавсаргана. Мөн орон нутгаас хэрэглэх элс, хайрганы шинжилгээний дүнг замын барилгын хувийн хэрэгт хавсаргана.

Боловсруулсан:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



М.ГЭРЭЛТ-ОД